

Таны хамар үнэхээр найдвартай юу? Үгүй ч байж магадгүй! 2021 оны 9-р сар



Юу тохиолдсон бэ? 2009 оны 6-р сарын 9-ний өдөр АНУ-ын Хойд Каролинагийн Гарнер хотод байгалийн хий дэлбэрсний улмаас мах боловсруулах үйлдвэр сүйрсэн. Барилгын нуралтад өртсөн гурван ажилтан амиа алдаж, дөрвөн ажилтан ноцтой түлэгдсэн ба 71 хүн эмнэлэгт хүргэгдсэн байна. Гурван гал сөнөөгч үйлдвэрийн хөргүүрийн системээс алдагдсан хорт бодис буюу хуурай аммиакт өртжээ. Ойролцоогоор 8165кг аммиак алдагдаж, үйлдвэрийн томоохон талбайг сүйрүүлжээ.

Шалтгаан нь юу байсан бэ? Үйлчилгээний өрөөнд хийгээр ажилладаг ус халаагуур шинээр угсарч байсан ус халаагуур үйлдвэрлэгч компанийн ажилтан шинэ хийн хоолойны доторх агаарыг шахаж гаргахын тулд байгалийн хий ашиглаж байжээ. Энэ үед хоолойноос гадагшилсан түлшний хий өрөөнд тархсан. Яндангийн сэнсээр тодорхой хэмжээний агаарын сэлгэлт явагдсан боловч тухайн хэсэгт шатамхай хий илрүүлэгч багаж ашиглаагүй байсан. Ажилтнууд хоолойны агаар бүрэн цэвэрлэгдсэн эсэхийг тогтоохын тулд өөрсдийн үнэрлэх эрхтэнд найддаг байсан.

Ямар алдаа гарсан бэ? Ойролцоо байсан ажилтнуудын зарим нь газын хийг үнэрлэсэн, зарим нь үнэрлээгүй аж. Газын хийн үнэрийг анзаарсан ажилтнууд ус халаагуурыг асаах үеийн хэвийн үзэгдэл гэж бодсон учир санаа зовоогүй байна. Үйлдвэрлэгч болон компанийн ажилтнууд хийн цэвэрлэгээний улмаас үйлчилгээний өрөөнд байгалийн хий аюултай хэмжээгээр хуримтлагдаж байгааг буюу тэсрэх түвшний доод хязгаараас (LEL) хэтэрсэн болохыг мэдээгүй. Өрөөнд цахилгаан төхөөрөмж гэх мэт хэд хэдэн галын эх үүсвэр байсан нь газын хийг ноцоосон байж болзошгүй.

Та мэдэх үү?

- Зарим төрлийн хийг хэсэг үнэрлэсний дараа үнэрлэх мэдрэмж саардаг. Үүний нэг нь хүхэрт устөрөгч (H₂S) болон байгалийн хийнд үнэр оруулахад ашигладаг хий юм.
- Хүн бүрийн тодорхой төрлийн үнэрийг ялгах төрөлхийн чадвар нь янз бүр байдаг ба үүнд ханиад, ковид зэрэг амьсгалах эрхтэнд үйлчилдэг хүчин зүйлс нөлөөлдөг.
- Химийн бодистой орчинд тогтмол ажилладаг ажилтнууд үнэрт дасах, мэдрэмжгүй болох зэрэг шалтгааны улмаас үнэр танихгүй байх тохиолдол гардаг.
- АНУ-ын Хөдөлмөр Хамгаалал, Эрүүл Ахуйн Үндэсний Хүрээлэнгээс (NIOSH) гаргасан үнэрлэх мэдрэмж саарах тухай товхимол байдаг.

[\(https://www.cdc.gov/niosh/docs/2021-106/\)](https://www.cdc.gov/niosh/docs/2021-106/)

- Хязгаарлагдмал, давчуу орчинд тархсан шатамхай уур, хий хуримтлагдсаар шатамхай хийн манан үүсгэдэг.
- Газ хэмжигч зөөврийн багаж бол аюултай хийг илрүүлэх, хэмжээг нь хянах хамгийн шилдэг арга юм. Ажлын талбайд хий хэмжих тохирсон багаж ашиглах, ашиглахын өмнө заавал тохиргоо хийдэг байх хэрэгтэй.
- Хийг тогтмол хэмжих нь хийн алдагдлыг илрүүлэхэд тустай. Харин тасралтгүй хэмжих нь ажлын талбайд аюултай хийг хянах хамгийн шилдэг арга юм.

Та юу хийж болох вэ?

- Хортой хийг илрүүлэхэд үнэрлэх эрхтэндээ хэзээ ч найдаж болохгүй. Ингэх нь эрсдэлтэй. Хэрэв та хортой хий үнэрлэсэн бол тухайн хэсгээс шууд холдох хэрэгтэй **бөгөөд** ахлах ажилтандаа даруй мэдэгд.
- Хортой хийг шахаж гаргах шаардлагатай бол зохих журмын дагуу болгоомжтой гүйцэтгэ. Хортой хий шахаж гаргах ажлыг агаар сэлгэлт сайтай орчинд хийх ёстой.
- Хортой хий агуулсан шугам хоолойг задлах, нээхийн өмнө аюулыг хянах үзлэг хийж, аюулгүй ажиллагааны бүх шаардлагатай системийн хэрэгжилтийг хангахын тулд зохих зөвшөөрлийг мөрд.
- Газ хэмжих багаж ашиглахын өмнө мэргэжлийн ажилтан тухайн хийд зориулсан тохиргоог хийх ба багажийг үйлдвэрийн зааварчилгааны дагуу ашиглах ёстой.

Зориулалтын газ хэмжигч ашигла! Хортой хий илрүүлэхэд өөрийн үнэрлэх мэдрэмжид бүү найд.